

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240103003 дугаартай “Цагаан цав” усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн уурхай хүртэл ус татах шугам хоолойн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна.

Д/д	Тодруулга	Тодруулгын хариу
1	ТШЗ 19.3 –т ЗТ – 4.4. Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг, ЗТ – 7.1. Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг гэж заасан байгаа тул ЗТ – 4.4, ЗТ – 7.1 заалтууд дүйцэх эсэхийг тодруулж өгнө үү.	ТШЗ 19.3-т тусгагдсан ЗТ–4.4. /Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг/ тусгай зөвшөөрлийн заалт нь “Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл” суурь нөхцөл шаардлага бөгөөд ЗТ-7.1 /Ус хангамж, ариутгах татуургын гол (магистраль) шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл/ заалттай дүйцэхгүй болно.
2	ТШЗ 19.3-т Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас олгодог ЗТ-4.1 гэсэн тусгай зөвшөөрөл шаардсан байна. ЗТ-4.1 нь Өндөр төвөгшилтэй бүх төрлийн барилга байгууламжийн архитектур, барилга бүтээцийн зураг төсөл боловсруулах бөгөөд энэ ангилалд 30-51 м өндөртэй 9-16 давхар орон сууцны өндөр барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн заалт юм. Ус дамжуулах шугам хоолойн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулахад шаардлагатай эсэхийг тодруулж өгнө үү	ТШЗ 19.3-т шаардсан тусгай зөвшөөрөл ЗТ-4.1 нь Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 147 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралтын 4. Өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл гэсэн суурь нөхцөл шаардлагад хамаарах тул зарлагдсан төсөл арга хэмжээнд шаардлагатай тусгай зөвшөөрөл гэж ойлгоно.

Жич: Дээрх тодруулгын хариу нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.